

СЭДЭВ 1.

АРДЧИЛСАН НИЙГЭМ ДЭХ СОНГУУЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ





СОНГУУЛЬ ГЭЖ ЮУ ВЭ?

Сонгуулийн эрх бүхий иргэдийг оролцуулан санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийхийг сонгууль гэдэг. Монгол Улсын Үндсэн хуулиар “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын бүх ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”¹ гэж заасан байдаг. Иймээс сонгууль нь Монголын ард түмэн төрийн болон орон нутгийн өөрөө удирдах эрхээ хэрэгжүүлэх үндсэн арга мөн.

Сонгуулийн тухай хуулиар² сонгуулийн үндсэн зарчим нь сонгуулийн эрх бүхий иргэд

- ✓ нийтээрээ,
- ✓ чөлөөтэй,
- ✓ шууд сонгох зарчмын үндсэн дээр
- ✓ саналаа нууцаар гаргаж сонгох эрхийг хангахад үндэслэнэ.

Сонгууль нь бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй.³



СОНГУУЛИЙН ЭРХ БҮХИЙ ИРГЭН ГЭЖ ХЭН БЭ?

18 насанд хүрсэн Иргэний бүртгэлд бүртгүүлсэн
Эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэн.



СОНГОГЧ ГЭЖ ХЭН БЭ?

Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн, сонгуулийн эрх бүхий иргэн.

¹МУ-ын Үндсэн хууль, 3 дугаар зүйл 1 дэх хэсэг







²Сонгуулийн тухай хууль, 4 дүгээр зүйл

³Сонгуулийн тухай хууль, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг



СОНГУУЛЬД ОРОЛЦОХЫН АЧ ХОЛБОГДОЛ ВИДЕО ҮЗЭХ

Сонгуульд оролцохын ач холбогдлын талаар видео үзэн сонгуульд оролцохгүй байснаар ямар үр дагавартай талаар ярилцаарай.





Сонгуульд яагаад оролцох, эс оролцох талаар өөрсдийн саналаа цаасан дээр бичин “Сонгуульд оролцоно”, “Сонгуульд оролцохгүй” гэсэн хоёр модон дээр наагаад бүлгээр ярилцаарай. Сонгуульд оролцохгүй байх шалтгаангүй болгох ямар арга зам бий вэ?

“Сонгуульд оролцоно”



“Сонгуульд оролцохгүй”



СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ТУХАЙ⁴

Сонгууль зохион байгуулах, санал авах, дүн гаргах, парламентын суудал хуваарилах олон янзын арга, дүрэм байдаг. Эдгээрийн нийлбэр цогцыг сонгуулийн тогтолцоо буюу систем гэдэг. Олонхийн саналаар буюу мажоритар систем, хувь тэнцүү төлөөллийн буюу пропорционал систем гэсэн үндсэн хоёр хэлбэр бий.

Мажоритар систем

Уг систем нь дотроо хоёр төрөл байдаг:

1. Ердийн олонхийн буюу мажоритар систем. Нэр дэвшигч сонгуульд ялахын тулд тухайн тойрогт санал өгсөн сонгогчдын 50%+1 санал авсан байх ёстой. Эхний шатанд нэр дэвшигчдийн хэн нь ч ердийн олонхийн санал авч чадаагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч хоёр дахь шатны сонгуульд өрсөлддөг. 1990 онд БНМАУ-ын АИХ-ын депутатуудыг сонгох сонгуулийг энэ системээр явуулсан.

⁴Залуу сонгогч танаа гарын авлага. Сонгогчийн боловсрол төв. Хуудас 8-9

2. Харьцангуй олонхийн санал авсан нэр дэвшигч ялсанд тооцогдох систем. Нэр дэвшигч өрсөлдөгчдөөсөө харьцангуй олон санал авсан байвал саналын тоо 50% хүрсэн эсэхийг үл харгалзан түүнийг ялсанд тооцдог. Сонгууль нэг шаттайгаар явагдах тул нэр дэвшигч цөөн санал авсан ч хамгийн олон санал авсан тохиолдолд парламентын гишүүн болох боломж олгодог талтай. Манай улсад 1994-2012, 2016 оноос энэ системээр сонгуулиа явуулж байна.

Мажоритар системээр явагдаж буй тохиолдолд сонгуулийн ирцээс хамаарч дараах үр дагавар гарч болох юм.

“ИРЦ ӨНДӨР” СОНГУУЛЬ

- ✓ Иргэдийн итгэл хүлээсэн, олонхийн санал авсан төлөөлөгч сонгогдоно.
- ✓ Бидний татварын мөнгөөр зохион байгуулж буй сонгууль дахин явагдахгүй.
- ✓ Олонхи иргэдийн сонгосон нам, эвсэл Засгийн газраа байгуулан мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлнэ.
- ✓ Олонхийн саналаар сонгогдсон төлөөлөгчөөр дамжуулан нийт иргэдийн эрх ашигт нийцсэн төрийн бодлого хэрэгжинэ.

“ИРЦ БАГА” СОНГУУЛЬ

- ✗ Ирц хүрэхгүй бол сонгуулийг дахин зохион байгуулж, төсвийн үргүй зарлага нэмэгдэнэ.
- ✗ Цөөн санал өгсөн хүмүүсээс илүү санал авсан төлөөлөгч сонгогдож олонхийн саналыг бүрэн төлөөлж чадахгүй.
- ✗ Цөөнхийн саналаар гарсан намын бодлого, үйл ажиллагаа нийт иргэдийн эрх ашигт нийцэхгүй байх эрсдэлтэй
- ✗ Цөөнхийн саналыг дагаж мөрдөхөөс өөр аргагүйд хүрнэ

Пропорционал систем

Хууль тогтоох байгууллага болох парламентын суудлыг сонгогчдоос авсан саналынх нь тоотой хувь тэнцүүлэн намуудад хуваарилах сонгуулийн системийг ийнхүү нэрлэдэг. Дотроо олон хувилбартай.

1. Хамгийн түгээмэл дэлгэрсэн арга нь улс төрийн нам, эвслээс нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаар санал авах хэлбэр юм. Сонгууль явуулахдаа олон мандаттай, том тойргуудыг байгуулж, нам, эвслүүд нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаа тойрог бүрээр гаргана. Зарим оронд улсаа бүхэлд нь нэг тойрог болгосон ч байдаг. Сонгогч аль намын төлөө саналаа өгч буйгаа илэрхийлэхийн зэрэгцээ нэр дэвшигчдээс чухам хэнийг нь сонгож байгаагаа тэмдэглэж болно. Манай УИХ-ын 2012 оны сонгууль хосолмол системээр явагдаж нийт 76 гишүүний 48-ыг мажоритарээр, 28-ыг пропорционалаар сонгож байсан.
2. Парламентын суудлыг хувь тэнцүүлэн хуваарилах хэд хэдэн аргачлал байдгаас өргөн хэрэглэгддэг нь квот (босго) юм. Энэ системийн өвөрмөц тал нь нийгэмд оршин буй олон янзын үзэл бодол парламентад тусгалаа олох боломжийг бий болгодогт оршино. Тухайлбал, нийт парламентын суудлын 30 хувийг эмэгтэйчүүдэд, 5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд, 5 хувийг үндэсний цөөнхөд хуваарилдаг тогтолцоотой улсууд бий. Дээр дурдсан квотын хэмжээ улс орон бүрт өөр өөр байна.



СОНГОГДСОН ЕРӨНХИЙЛӨГЧ, УИХ-ЫН ГИШҮҮН, ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ЮУ ХИЙДЭГ ВЭ?

Ерөнхийлөгчийн бүрэн эрх⁵ :

- Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг товлон зарлах буюу улс орны чанартай хойшлуулшгүй чухал асуудлыг хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын ээлжит бус чуулган чуулахыг санаачлах;
- Ерөнхийлөгчийн санаачилгаар ээлжит бус чуулган чуулах бол Улсын Их Хурлын дарга, Ерөнхийлөгчтэй тохиролцсон хугацаанд уул чуулганыг товлон зарлах;
- Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш 45 хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргах Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах бол зарлиг гаргах;
- Хууль санаачлах бүрэн эрхийнхээ дагуу боловсруулсан хуулийн болон түүнтэй холбогдох шийдвэрийн төслийг хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх;
- Ард нийтийн санал асуулга явуулах саналыг хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хуралд оруулах;
- Улсын Их Хурлаас тодорхойлсон Монгол Улсын дотоод, гадаад бодлогод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан болон үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй байгаа, түүнчлэн Засгийн газарт чиглэл өгөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг Засгийн газар хэрэгжүүлээгүй нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд саад болсон гэж үзвэл Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах;
- Бүх шатны шүүгчийг хуульд заасны дагуу томилох;
- Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээллийг зохих байгууллагаас гаргуулан авч, шаардлагатай асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанд санаачлан оруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар өгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих;
- Гадаад харилцаанд Монгол Улсыг бүрэн эрхтэй төлөөлж, мэдэгдэл, хэлэлцээ хийх, хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах;
- Хууль тогтоомжид заасны дагуу улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах, хүртээсэн цол, шагнасан одон, медалийг хасах;
- Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;

⁴Ерөнхийлөгчийн тухай хуулийн 2 дугаар бүлэг. www.president.mn цахим хуудсаас

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх⁶ :

- Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачлах; иргэд, байгууллагаас ирүүлсэн саналыг судлан үзэж, шаардлагатай гэж үзвэл төсөл санаачлах, шаардлагагүй бол энэ тухай хариуг бичгээр өгөх;
- Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүнд орох, нэг Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарч өөр Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох. Одоо ажиллаж байгаа байнгын хороо⁷:
 - Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо
 - Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо
 - Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо
 - Өргөдлийн байнгын хороо
 - Хууль зүйн байнгын хороо
 - Төрийн байгуулалтын байнгын хороо
 - Төсвийн байнгын хороо
 - Эдийн засгийн байнгын хороо
- Хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж хариулт авах, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах;
- Улсын Их Хурлын шийдвэрээр байгуулагддаг байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, сонгогдох буюу томилогдох албан тушаалтны талаар үг хэлж байр сууриа илэрхийлэх, санал, дүгнэлт гаргах;
- УИХ-аас удирдлага нь томилогддог, УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагууд нь:
 - Улсын Их Хурлын Тамгын газар,
 - Санхүүгийн Зохицуулах Хороо,
 - Үндэсний Аудитын Газар,
 - Монгол банк,
 - Үндэсний Статистикийн Хороо,
 - Сонгуулийн Ерөнхий Хороо,
 - Авлигатай Тэмцэх Газар,
 - Үндсэн Хуулийн Цэц,
 - Хүний Эрхийн Үндэсний Комисс,
 - Төрийн Албаны Зөвлөл
- Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга, асуулт тавьж хариуг нь хуульд заасан хугацаанд авах, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл санаачилж хэлэлцүүлэх;
- Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан шийдвэрлэж хариуг нь шууд өгөх, эсхүл хариуцан шийдвэрлэх эрх, үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлж энэ тухай хариу мэдэгдэх;
- Бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аль ч байгууллагад чөлөөтэй нэвтэрч, хэнтэй ч хүлээгдэлгүй уулзах, шаардлагатай асуудлаар тайлбар авах;
- Хөрөнгө, орлогын мэдүүлгийг тогтоосон журмын дагуу үнэн зөв гаргах.

⁶ УИХ-ын тухай хууль, 7 дугаар зүйл

⁷ www.parliament.mn цахим хуудсаас

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх⁸:

- Хурлын дарга, Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Тэргүүлэгчдийг сонгох, хороо байгуулах, тэдгээрт сонгогдох, бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт гаргах;
- Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх санал гаргах;
- Хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулах;
- Хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулга тавьж хариуг нь авах;
- Хуралдааны шийдвэрийн биелэлтийг тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр шалгах, шаардлага тавьж биелэлтийг хангуулах;
- Сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах;
- Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу нийтийн сонсгол явуулах хүсэлт гаргах.



Сонгосон төлөөлөгчдийнхөө хийдэг ажлыг хэр сайн мэдэж байгаа талаар саналаа солилцоорой.



⁸ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйл